

ТҮМЭН ГАЗРЫН ЦАГААН ХЭРЭМ

ЛҮ ШҮНЬ*

Түмэн газрын их хэрэм минь! Газрын зураг дээр нарийхан зурвасаар тэмдэглүүлсэн чамайг, энэ дэлхийн хаана ч бага ч атугай мэдлэг суусан хүн бүр андахгүй бизээ.

Чиний төлөө үеийн үед хичнээн хөдөлмөрч хүмүүс амь насаа алдаа вэ! Нүүдэлчин аймгийн довтолгооныг тогтоон барьж чадах уу чи? Одоо зөвхөн эртний дурсгалт зүйл болон үлджээ. Баларч арилахгүй нь мэдээж бол уу, эсэхүл хамгаалуулан үлдэх нь юун магад.

Одоо ч эргэн тойрноос түмэн газрын их хэрэм хүрээлж байгаа мэт надад санагдах юм. Түмэн газрын их хэрмийг босгосон зүйл гэвэл эртний тоосго бөгөөд үүгээр түүгээр нь шинэ цагийнхаар нөхөх ажээ. Аль алин нь нийлээд хотын хана хэрэм болж хүмүүсийг бүслэн хүрээлнэ.

Их хэрэмд шинэ тоосго нэмэхээ болих цаг хэзээ ирэх бол.

Ай аугаа их атлаа хараан зүхүүштэй их цагаан хэрэм минь ээ!

1925 оны 5 дугаар сарын 11.

ЦАС

Дулааны оронд хур бороо, хүйтэн, хатуу гялалзаж гялтганасан цас мөс болж хэзээ ч хувирдаггүй билээ. Түүнийг мэдэх хүмүүс ч бас хэтэрхий дагнамал хэмээн ад үзэж, ямар гайгаар ийм оронд төрөв гэх нь халгүй.

Нанхиад орны өмнө нутагт газар цас нь үлэмж үзэсгэлэн төгс болоод чийглэг тул ойртон буй урины амьсгаа, найртай хаврыг зөгнөсөн дохио хэмээлцэнэ. Цайвар цагаан биеэрээ нэвсийн хучсан цасны дороос уулын цайны үзмэн ягаан өнгө тодорч, зэрлэг Лексвийн модны хар ногоон эмжээртэй цэцгэс ялгаран, царцангисна. Харин эрвээхэй нисч, зөгий бал бурмаа хураан буй эсэхийг үнэндээ би ажсангүй.

Цасан дунд торойх өвлийн цэцэг, олон зөгий гүнгэнэн дүнгэнэх мэт миний харцанд бууж байв.

Нарийн хөөрхөн хуруутай хүйтэнд хацар нь ягааран жаалууд долоо наймаараа нийлж шшугилдан цасан өвгөн босгоно. Олигтой болж өхгүй болохоор хэн нэгнийх нь эцэг ирж элбэлцэнэ. Цасан өвгөн хүүхдээсээ хавьгүй өндөр болж, нарийн ажвал өвгөн ч юм уу? Бөгс нь бүдүүн толгой нь нарийхан тул ваар ч юм уу гэмээр нэгэн цасан овоо хасын цагаан болоод сэрүүн тунгалаг, өөрөөсөө туяа цацруулам сүрлэг ажээ. Хүүхдүүд хушга олж авчран нүдий нь хийгээд, хэн нэг нь эхийнхээ уруулын будагнаас хулгайлж, уруулы нь будав. Одоо харин цасан өвгөн гэхэд төстэй болжээ. Гялалзсан нүдтэй, улаан өвгөн гэхэд төстэй болжээ. Гялалзсан нүдтэй, улаан уруултай өвгөн гуай цасан олбог дээрээ тухтайхан сууна.

Маргааш нь хэдэн жаал, өвгөний амар мэндийг лавлахаар тавьж буув. Өвгөний урд очоод алга ташиж, толгой дохиж, тачигнатал хөхрөн бишгүй л цамнацгаав. Өвгөн гуай цор ганцаараа луглайн суусаар л цэлмэг өдөр өвгөний цасан бие нимгэрэвч, хүйтэн шөнө мөлчийтлөө хөлдөж усан болор болно. Маргааш нь гэгээн наран ахин гийгүүлж, хүн дүрсий нь алдуулан улаан уруулы нь хүртэл арилгачихав.

Харин умар зүгт цас нь орохдоо, элс шиг будаа шиг ширхэг ширхгээр бууж, байшин гэрийн дээвэр, хатсан өвс бут газар дэлхийг хучна. Дотор нь гал түлдэг болохоор байшин, гэрийн дээврийн цас удалгүй арилна. Харин газар дэлхийг хучсан цас цав цагаанаараа цэлийж, тунгалаг өдөр нүд гялбуулан, салхи хөдөлбөл шуурч огторгуйд манаран дэгдэж, өнгө туяа цөм хослоно.

Жавартай тэнгэрийн дор хязгааргүй талд салхины аясаар хөөрөн бужигнагч цагаан цас нь борооны сүнс буюу ...

Энэ бол ховорхон тохиолдох цас, энэ бол төрөл арилжсан бороо, энэ бол борооны сүнс.

1925 оны 1 дүгээр сарын 28

*Лү Шүнь. Хятадын их зохиолч. “Мөнх гийгч дэнлүү” номоос авав. Д.Бандихүүгийн орчуулга.